## НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хог хаягдлын гэрээг Баянжаргалан сумын Баянжаргалан сумын 3-р багийн засаг даргатай байгуулж, гэрээний дагуу хог хаягдал тээвэрлүүлж ажилласан.



**ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ**

2024 он 09 сарын 05 өдөр № 01 Баянжаргалан сум

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17-р зүйлийн 2,6 дахь заалт , Хог хаягдлын тухай хуулийн 8.4, 9.2, 20.1,20.2 дугаар зүйл, Сумын ИТХ-ийн 2019 оны 05 тоот тогтоолыг үндэслэлээ.

Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, дахин боловсруулж эргүүлэн ашиглах, тээвэрлэх булах болон орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллаж амьдрах орчныг бий болгоход оршино.

**Хоёр. Гэрээ байгуулагч талууд**

Нэг талаас Дундговь аймгийн Баянжаргалан сумын ЗДТГ-ыг төлөөлж 3-р багийн Засаг дарга Батбилэг овогтой Пүрэвбаяр Нөгөө талаас “Жунюань” ХХК Дундговь аймгийн Баянжаргалан сумын 3 -р багт улсын бүртгэлийн гэрчилгээ 9019016141 тоот регистрийн дугаартай “Жунюань” ХХК-ийн Уурхайн дарга Энхтуул овогтой Шинэбаяр нар харилцан тохиролцож 2024 оны 01 сарын 01 -ний өдрөөс 2024 оны 12 сарын 31 –ийг хүртэл энэхүү гэрээг байгуулав.

**Гурав. Төлбөр тооцсон байдал**

Баянжаргалан сумын 2019 оны 12 дугаар сарын 19-ны ИТХ-ын 05 тогтоолд заасны дагуу сард 80000 төгрөгөөр тооцов.
Сарын төлбөр
Жилийн төлбөр 960000 төг

**Дөрөв. Сумын ЗДТГ эрх**

1 . Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын хууль, Ариун цэврийн тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах
2 . Иргэд аж ахуйн нэгж , байгууллагын хог хаягдал гаргасны төлбөрийг төвлөрүүлэх
3 . Иргэд аж ахуйн нэгж , байгууллагын хог хаягдлаа зориулалтын цэгт хаяж байгаа эсэхэд хяналт тавих
4. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хуваарийг тээвэрлэгчтэй гэрээ байгуулж хэрэгжилтэнд хяналт тавих.

**Тав. Иргэн ААН байгууллагын эрх үүрэг**

1. Өөрийн байгууллагын үйл ажиллагаанаас гарсан ахуйн хуурай хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд хадгалж байх.

*Зураг 32. Хог хаягдлын гэрээ*



2. ААН байгууллага нь хог хаягдал гарсан төлбөрөө улирал бүрийн сүүл сарын 15-ны дотор гэрээнд заасны дагуу Дундговь аймгийн Баянжаргалан сумын татварын байцаагчтай холбогдож хог хаягдлын төлбөрөө төлөх.
3. Хог хаягдлыг ангилан ялгаж байх
4. Ахуйн болон үйлдвэрлэлийн хогийг тогтсон хугацаанд цэвэрлэж тээвэрлэх, хог хаягдлын талаарх дүрэм журам, стандартын шаардлагыг хангаж зориулалтын цэгт хаяж байхад анхаарах.
5. Үйлдвэр үйлчилгээний явцад үүсдэг хог хаягдлын хэмжээ, бусад мэдээллийг сумын захиргаанд мэдээлж байх.
6. Хог хаягдлыг ангилан хаях талаар мэдээллийг ажилтнуудад ээмшүүлэх, сургалт сурталчилгаа явуулах, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах.
7. Оршин суугаа газар орчмын хог хаягдлыг цэвэрлэх, олон нийтийг хамарсан ажилд оролцох.
8. Хуульд заасан журмын дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага албан тушаалтнаас шаардах.
9. Үүссэн аюултай хог хаягдал, түүний эх үүсвэрийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх.
10. Дундговь аймгийн Баянжаргалан сумын татварын байцаагчтай холбогдож хог хаягдлын төлбөрөө төлөх.

**Зургаа. Гэрээний хариуцлага**

19. Аж Ахуй нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө удаан хугацаагаар төлөөгүй болон ил задгай хог шатаасан, зориулалтын бус газар хог хаягдал хаясан нөхцөлд өр авлагыг барагдуулах ба учруулсан хохиролыг арилгах шаардлагатай тохиолдолд холбогдох дээд шатны байгуулагад хандан хог хаягдлын тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.
20. Аж Ахуй нэгж байгууллага нь энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл хоёр талын хамтарсан төлөөлөгч тухай бүр шийдвэрлэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМ
Аргатай 7-р багийн Засаг дарга
______ / Б.Пүрэвбаяр /
Утас: 99462846

“ЖУНЮАНЬ” ХХК
Уурхайн дарга
______ / Э.Шинэбаяр /
Утас: 88045749

Зураг 33. Хог хаягдлын гэрээ



**Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information**

Журналын/Journal No: 000901129791

Системийн огноо/System Date: 2024.10.17 17:12:55

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт/From | Дансны/Картын дугаар Account/Card number 5070361718 | Нэр/Name Н******О МӨНГӨНЧИМЭГТ | Дүн/Amount 960,000.00 MNT | Ханш/Rate 1.00 |
| / Есөн зуун жаран мянган төгрөг/ | | | | |
| Кт/To | Банкны дугаар/Branch No 90<br>Дансны/Картын дугаар Account/Card number 100080500947 | Банкны нэр Bank Name Төрийн Сан<br>Нэр/Name Ду.Ба Хог хаягдлын хураамж | 960,000.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:
ЕВ-2812231 Жун-Юань ГХОХХК хог хаягдлын хураамж

*Зураг 34. Хог хаягдлын гэрээний төлбөр төлсөн баримт*

## ЕС. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд ажилчдыг хувцас хэрэгслээр хангаж ажилласан бөгөөд уг зардалд нийт 1 750.0 мян.төг-ийг зарцуулсан. Түүнчлэн орон нутагтай хамтран ажиллах гэрээг байгуулж, гэрээний дагуу эхний санхүүжилт болох 30.0 сая.төгрөгийг байршуулсан. Мөн Баянжаргалан сумын Аргатай 3-р багийн өдөрлөгийг зохион байгуулахад хамтран оролцож, тэмцээний шагналын сан болох 6.0 сая.төгрөгийг гаргасан.




*Зураг 35. Ажилчдыг хувцас хэрэгслээр хангасан байдал*



Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 000862162454

Системийн огноо/System Date:2024.09.11 09:46:07

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт/From | Дансны/Картын дугаар Account/Card number 5070361718 | Нэр/Name H******О МӨНГӨНЧИМЭГТ | Дүн/Amount 30,000,000.00 MNT | Ханш/Rate 1.00 |
| / Гучин сая төгрөг / | | | | |
| Кт/To | Банкны дугаар/Branch No 34 Дансны/Картын дугаар Account/Card number 221500231581 | Банкны нэр Bank Name Төрийн банк Нэр/Name ӨНӨ ӨЛЗИЙ АРВИЖИХ | 30,000,000.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:
жун-юань ххк зас

*Зураг 36. Орон нутагтай хамтран ажиллах гэрээний хүрээнд төлсөн төлбөрийн баримт*



БАТЛАВ
ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА М.АНХБАЯР

БАТЛАВ
"ЖУН-ЮАНЬ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Н.МӨНГӨНЧИМЭГТ

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ, ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ, ХАНДИВ, ТУСЛАМЖ ӨГӨХ ЧИГЛЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр №ДУЗДТГ/УУ2024090512 Мандалговь хот

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.10 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 179-р тогтоол, Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалт, Дундговь аймгийн Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг үндэслэн нэг талаас Нутгийн захиргааны байгууллага Дундговь аймгийн Засаг даргын тамгын газрыг төлөөлж Дундговь аймгийн Засаг даргын орлогч М.Анхбаяр, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай хамаарах Баянжаргалан, түүнийг төлөөлж Баянжаргалан сумын Засаг дарга О.Ууганбаатар /цаашид А тал гэх/, нөгөө талаас "ЖУН-ЮАНЬ" ХХК РД:2812231 /цаашид Б тал гэх/- ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Н.Мөнгөнчимэгт нар харилцан тохиролцож энэхүү гэрээг 2024 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл байгуулав.

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1 Энэхүү гэрээгээр талууд байгаль орчныг хамгаалах, Уурхай, төслийн бүтээн байгуулалттай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, уул уурхайн олборлолт, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах чиглэлээр хамтран ажиллах, ажлын уялдаа холбоог сайжруулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Б тал нь аймаг, орон нутгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, орон нутгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.

1.3 Энэхүү гэрээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Татварын тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд явагдана.

**ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ**

2.1 Гэрээний хамрах хүрээг Дундговь аймгийн Баянжаргалан сумын "Зэрэгцээ" нэртэй хайлуур жоншны орд дээр MV-008652 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "ЖУН-ЮАНЬ" ХХК-ийн уурхай (цаашид "төсөл" гэх)-үүдийн үйл ажиллагааны хүрээнд орон нутагтай хамтран ажиллах гэрээ гэж ойлгоно.

2.2 Хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэхэд талууд дараах үндсэн чиглэлүүдийг баримтална. Үүнд:

2.2.1 Уурхай, төслийн бүтээн байгуулалттай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх,
2.2.2 Байгаль орчныг хамгаалах,
2.2.3 Ажлын байрыг нэмэгдүүлэх,
2.2.4 Орон нутгийн жижиг дунд бизнесийн үйл ажиллагааг дэмжих,
2.2.5 Соёлын өвийг хамгаалах,
2.2.6 Боловсон хүчний бодлогыг дэмжих,

2.3 Нутгийн захиргааны байгууллага нь компанийн үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

2.4 Талууд хамтран энэхүү гэрээний 2.2.1-2.2.3-т заасан асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно.

*Зураг 37. Орон нутагтай хамтран ажиллах гэрээ*



2.5 Б тал нь тусгай мэргэжил шаардахгүй ажлын байрыг нэн тэргүүнд үйлдвэр, уурхай байрлаж буй сумын иргэдэд санал болгох, дараагийн шатанд зэргэлдээх сумдын иргэдийг ажлын байраар хангах замаар орон нутгийн иргэдийг авч ажиллуулахад анхаарч ажиллана.

2.6 Б тал нь төслийн үйл ажиллагааны нөлөөнд өртсөн орон нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах үүднээс орон нутгийн бизнесийг дэмжих төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар хамтран ажиллана.

**ГУРАВ. НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН /А тал/ ЭРХ, ҮҮРЭГ**

3.1. Ерөнхий зүйлс:

3.1.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллана

3.1.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх

3.1.3 Компани үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, ИТХ-д тавьж шийдвэрлүүлэх;

3.1.4 Гэрээний хэрэгжилтэд холбогдох төрийн байгууллагууд хяналт тавьж ажиллана

3.1.5 Аймаг, сумын хөгжилд оруулсан хөрөнгийн зарцуулалтыг жил бүр тооцож, ил тод мэдээлнэ.

3.1.6 Орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллагад сурталчилна.

3.1 Дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр.

3.1.1 Уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэхэд тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран ажиллана

3.1.2 Уурхайн орчны аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн эсэхэд хяналт тавьж ажиллана.

3.2 Байгаль орчныг хамгаалах чиглэлээр.

3.2.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний (БОМТ) хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийн хуваарь үнэлж, ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн дараа жилийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэх

3.2.2 Б талаас орон нутагт зохион байгуулж байгаа байгаль орчны чиглэлийн танилцуулга, сургалт, өдөрлөгт иргэд, олон нийтийг идэвхтэй оролцуулна.

3.3 Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажиллах хүчнийг сургах чиглэлээр.

3.3.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байрны талаарх мэдээллийг иргэдэд нээлттэй хэлбэрээр хүргэх;

3.3.2 Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах;

3.3.3 Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч, саналыг нь авах;

3.4 Мэдээлэх/ Санал авах/ Хэлэлцүүлэх чиглэлээр.

3.4.1 Иргэдэд төслийн хэрэгжилтийн талаар мэдээлэх;

3.4.2 Төслийн хэрэгжилтэд санал авах;

3.4.3 Гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, аймаг (сум, дүүрэг)-ийн ИТХ-аар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр энэ тухай иргэдэд мэдээлэх;

3.4.4 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэй байгуулсан орон нутагтай хамтран ажиллах гэрээний талаар иргэдэд мэдээлэх;

**ДӨРӨВ. КОМПАНИЙН /Б тал/ ЭРХ, ҮҮРЭГ**

**4.1 Ерөнхий зүйлс.**

*Зураг 38. Орон нутагтай хамтран ажиллах гэрээ*



4.1.1 Нутгийн захиргааны байгууллагатай хамтран байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллана;
4.1.2 Гамшиг, осол, гал түймэр гарсан үед шаардлагатай туслалцаа үзүүлнэ.
4.1.3 Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг (нийслэл), сум (дүүрэг)-ын ИТХ-д хүргүүлнэ

4.2 Орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах, орон нутгийн санд дэмжлэг үзүүлэх чиглэлээр.

4.2.1 Энэхүү гэрээний хүчинтэй байх хугацаанд талууд тохиролцсон үндэс дээр Дундговь аймгийн орон нутаг хөгжлийн сангийн 100080052400 тоот дансанд /50,000,000/ наян сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх, Нийгмийн хариуцлагын хүрээнд олон нийтийн арга хэмжээнд /30,000,000/ гучин сая төгрөгийн дэмжлэг үзүүлнэ ; /журмын дагуу аймаг болон тухайн суманд хуваарилагдана/
4.2.2 Дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр.
4.2.3 Уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэхэд нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллана;
4.2.4 Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх авто тээврийн замын маршрутыг аймгийн "Ашигт малтмал тээвэрлэлтийн нэгдсэн маршрут"-тай уялдуулан аймгийн Засаг даргаар батлуулж, маршрутын дагуу, замын ашиглалт, засварыг хариуцан тээвэрлэлт хийнэ.

4.3 Байгаль орчныг хамгаалах чиглэлээр.

4.3.1 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, төлөвлөгөөний дагуу ажиллаж, аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан БОМТ-нд хянаж, дүгнэх ажлын хэсэгт жил бүрийн 11 сарын 01-ний дотор тайлангаа ирүүлж дүгнэлтийг гаргуулах;
4.3.2 "Тэр бум мод үндэсний хөдөлгөөн, "Дундговио ногооруулъя" дэд хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх;

4.4 Хөдөлмөр эрхлэлт, ажлын байр нэмэгдүүлэх, ажиллах хүчнийг сургах чиглэлээр.

4.4.1 Нийт ажлын байрны 70-с доошгүй хувьд тухайн орон нутгийн иргэдийг зохих түвшний сургалтад хамруулсны үндсэн дээр ажиллуулах;
4.4.2 ОН-ийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар ОН-ийн хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;
4.4.3 Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн ОН-ийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах;
4.4.4 Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутгийн хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох (тухайн нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн,) өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн урт хугацаагаар авч ажиллуулах тохиолдолд холбогдох хуулийн дагуу тухайн ажилтныг Засаг даргын Тамгын газарт бүртгүүлэх;

4.5 Орон нутгийн жижиг дунд бизнесийн хөгжилд хувь нэмэр оруулах чиглэлээр.

4.5.1 Орон нутгийн аж ахуйн нэгжийн санал болгосон бараа нь компанийн "Бараа, материал худалдан авах шалгуур үзүүлэлтүүд" болон үйлдвэрлэлийн хэрэгцээ, зориулалт, шаардлага, чанарын үзүүлэлтийг хангаж байгаа тохиолдолд дэмжиж ажиллана.
4.5.2 Нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан тохиолдолд эхний ээлжинд худалдан авах бодлого баримтлах, компанид шаардлагатай бараа, материал нийлүүлэх жижиг дунд үйлдвэрийн төсөл, хөтөлбөрийг дэмжиж ажиллана.

*Зураг 39. Орон нутагтай хамтран ажиллах гэрээ*

4.5.3 Гамшиг, осол, гал түймэр гарсан үед сайн дурын үндсэн дээр тухайн сум, орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон шаардлагатай бусад зүйлд туслалцаа дэмжлэгийг үзүүлнэ.

4.6 Мэдээлэх/ Санал авах/ Хэлэлцүүлэх чиглэлээр.

4.6.1 Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагаанысхаа талаар тухайн аймаг (сум, дүүрэг)-ийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч байх;

4.6.2 Тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна.

**ТАВ. ГЭРЭЭНИЙ ХЯНАЛТ**

5.1 Гэрээний хэрэгжилт болон холбогдох хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаа талаар Аймаг, сумдын Засаг дарга, холбогдох төрийн байгууллагууд болох (АЗДТГ, БОАЖГ, ГХБХБГ, ХХҮГ, Татварын газар, Цагдаагийн газар, Авто тээврийн газар) гэх мэт байгууллагууд болон нутгийн иргэдээр дамжуулан хяналт тавина.

5.2 Гэрээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Засаг даргын орлогчоор ахлуулсан аймгийн ОҮИТБС-ын дэд зөвлөл, тухайн сумын Засаг дарга, иргэний төлөөлөл гэсэн баг бүрэлдэхүүн гэрээний дагуу хянаж, дүгнэнэ.

**ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

6.1 Талууд гэрээний тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар улиралд багтаан дүгнэнэ.

**ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА**

7.1 Талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

7.2 Энэхүү гэрээг биелүүлэхэд талууд санаачлага гаргаж ажиллана.

7.3 Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

7.4 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь компанийг хуулиар хүлээсэн бусад үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

7.5 Б тал гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

**НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

8.1 Гэрээг тайлбарлах болон гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан, зөрчлийг тухай бүр, эв зүйгээр шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

8.2 Хэрэв маргаантай асуудлаар талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

**ЕС. БУСАД**

9.1 Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

9.2 Давтагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно. Энэ тухайгаа нэг сарын өмнө нөгөө талд бичгээр мэдэгдэнэ.

9.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно

9.4 Хэрэв гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулах шаардлага гарвал нөгөө талдаа 30 хоногийн өмнө харилцан бичгээр мэдэгдэнэ. Оруулсан нэмэлт өөрчлөлтийг гэрээнд хавсаргаснаар нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

БАЯНЖАРГАЛАН СУМЫН
ЗАСАГ ДАРГА ...................
/Ю.УУГАНБААТАР/
УТАС:99591050

"ЖУН-ЮАНЬ" ХХК-ИЙН УУРХАЙН ДАРГА Э.ШИНЭБАЯР
УТАС:88048799
ХАЯГ: Баянзүрх дүүрэг, 5-р хороо, Цайз зах 108 тоот

АЗДТГ-ын ХБГХОХ-ын мэргэжилтэн
............................ /М.Ганчимэг/
Утас: 70592895
Дундговь аймаг, Нутгийн захиргааны ордон
Аймгийн Засаг даргын тамгын газар

*Зураг 40. Орон нутагтай хамтран ажиллах гэрээ*

## Дундговь аймгийн Баянжаргалан сумын Аргатай 3-р багийн Багийн өдөрлөгийн удирдамж

**Нэг. Зорилго**

Ард иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, авьяас чадварыг нээн илрүүлэх хөгжүүлэх, биеийн тамир, спортын хөдөлгөөнд өргөнөөр хамруулах, ард иргэдийг нөхөрсөг хамтач багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэхэд оршино.

**Хоёр. Зохион байгуулагч**

- Аргатай 3-р багийн засаг дарга
- Иргэдийн нийтийн хурлын зөвлөлийн гишүүд

**Гурав. Явагдах хугацаа хамрах хүрээ**

1. 2024.09.07 нд 10:00 цагт эхлэнэ. Аргатай 3-р багийн иргэд болон Сумын төвд ажиллаж амьдарч байгаа иргэд оролцоно.

**Дөрөв. Тэмцээн явагдах төрлүүд**

1. Хуруу барих / 45-дээш насныхан /
2. 1 литр айргийг хэдэн минут секундад ууж дуусгах вэ / эрэгтэй эмэгтэй /
3. Гар барилдах тэмцээн / эрэгтэй эмэгтэй /
4. Хөгжөөнт бартаат буйхаа / Багаас 3 хүн/
5. **Олс таталт / Багаар /**
6. Бөхийн барилдаан / Багаас 1 хүн /
7. 4*100 метрийн гүйлт / Багаас 4 хүн 2 эмэгтэй 2 эрэгтэй хүн 18-29 30-39 40-49 50-60 насны уралдаан багаас 1 хүн /
8. Нум сум харваа

**Тав. Тэмцээний журам зохион байгуулалт**

1. Багийн өдөрлөг 10-н цагт эхлэнэ.
2. Өдөрлөгт ирсэн иргэдийг бүртгэж нас насны ангилалаар багт хуваана.
3. Ирсэн иргэдийн тооноос хамаарч багийн гишүүдийн тоог хязгаарлана.
4. Тэмцээн тус бүрд 1-5 оноо өгнө.
5. Багийн нийлбэр оноогоор 1, 2, 3, тусгай байр эзлүүлнэ.
6. Багийн ахлагч багийн гишүүдийг тэмцээнд орох үед бэлэн байлгах

*Зураг 41. Баянжаргалан сумын Аргатай 3-р багийн өдөрлөгийн удирдамж*



Дундговь аймгийн Баянжаргалан сумын
Аргатай 3-р багийн өдөрлөгийн төсөв

2024.09.04 Аргатай

| № | Төрөл | Байр | Хэмжих нэгж | Мөнгөн дүн | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | Шагнал | 1-р байр | 1 | 600000 | 1700000 |
| 2 | | 2-р байр | 1 | 500000 | |
| 3 | | 3-р байр | 1 | 400000 | |
| 4 | | Тусгай байр | 1 | 100000 | |
| 6 | | Орой хөгжөөнт тэмцээн | 3 | 100000 | |
| 7 | | Өргөмжлөл дугтуй | 3 | 100000 | |
| 8 | Ус ундаа чихэр жимс идээ | | 200 | 2000000 | 2200000 |
| 9 | Ямааны хорхог | 2 | | 200000 | 400000 |
| 10 | Айраг | | 100литр | 8000 | 800000 |
| 11 | Нум сум | | 2 | 300000 | 600000 |
| 12 | Соёлын төв техник хэрэгсэл | | 1 | 100000 | 100000 |
| 13 | Бусад зардал | | | | 200000 |
| Нийт дүн | | | | | 6000000 |

Төсөв гаргасан:

Аргатай 3-р Багийн засаг дарга: ............ / Б.Пүрэвбаяр /



**Зургаа. Шагнал урамшуулал**

- 1-р байр Өргөмжлөл мөнгөн шагнал
- 2-р байр Өргөмжлөл мөнгөн шагнал
- 3-р байр Өргөмжлөл мөнгөн шагнал
- Тусгай байр Өргөмжлөл мөнгөн шагнал

*19:00 цагаас Галын наадам , Цэнгээнт бүжиг, Хөгжөөнт тэмцээн*

Удирдамж боловсруулсан:

Аргатай 3-р Багийн засаг дарга: / Б.Пүрэвбаяр /

***Зураг 42. Багийн өдөрлөгийн төсөв***



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН

# ТАЛАРХАЛ

ЖУНЮАНЬ ХХК-ны хамт олонд

Дундговь аймаг Баянжаргалан сумын Аргатай 3 дугаар багийн **БАГИЙН ӨДӨРЛӨГ**-ийг ивээн тэтгэж санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлж хамтран ажилласанд нийт иргэдийнхээ өмнөөс чин сэтгэлийн талархал илэрхийлье.

ТА БҮХНИЙ ЦААШДЫН АЖИЛ ХӨДӨЛМӨРТ ӨНДӨР АМЖИЛТ ХҮСЬЕ

ХҮНДЭТГЭСЭН:
Дундговь аймгийн
Баянжаргалан сумын
Аргатай 3 дугаар
Багийн Засаг Дарга

2024.09.10

*Зураг 43. Багийн өдөрлөгийн талархал*

# АРАВ.ТУХАЙН ЖИЛИЙН ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хөрс, ус, агаарын чанарын шинжилгээг хийж гүйцэтгэсэн.



ГОВЬСҮМБЭР УЦУОШТ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ
ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

2024 10 04 Дугаар 25

Дугаар, он /№ : 09/18/2024
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : Жун Юань ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : БОШЛ-ийн инженер /код-1/
Дээжийн төрөл, тоо : Агаарын бохирдол
Сорьц авсан огноо : 2024.09.18
Дээжийн хэмжээ /мг/м$^3$/ : 20 минут $SO_2$-$NO_2$
Дээжийн тодорхойлолт : Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум
Шинжилсэн огноо : 2024.09.18 – 2024.10.04
Хуудасны тоо : 1

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий мг/м$^3$ | Азотын давхар исэл мг/м$^3$ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Кемп | IX/18 | 14:00 | 0.008 | 0.010 |
| 2 | Ялгалт | IX/18 | 14:30 | 0.009 | 0.014 |
| **Агаарын чанарын стандарт MNS 4585:2016** | | | | **0.450** | **0.200** |

Шинжилгээ боловсруулсан: БОШЛабораторийн инженер /Т. Оюунгэрэл/

Хянасан: Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш. Мөнгөнцэцэг/

*Зураг 44. Агаарын чанарын шинжилгээний хариу*

## ГОВЬСҮМБЭР УЦУОШТ

### БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

### ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

2024 оны 10 сарын 04 өдөр Дугаар 28 Чойр

| | | |
|---|---|---|
| Дугаар, он /№ | : | 09/18/2024 |
| Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас | : | Жун-Юань ХХК |
| Дээжийг авсан хүний нэр, албан тушаал | : | БОШЛ-ийн инженер /код-2/ |
| Дээжийн төрөл, тоо | : | Тоос, тоосонцор |
| Сорьц авсан огноо | : | 2024.09.18 |
| Дээжийн хэмжээ /мг/м³/ | : | 24 цаг |
| Дээжийн тодорхойлолт | : | Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум |
| Шинжилсэн огноо | : | 2024.09.18 – 2024.10.04 |
| Хуудасны тоо | : | 1 |

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | PM 2.5 мкг/м³ |
|---|---|---|---|---|
| 1 | Ажлын талбай | IX/18 | 24 цаг | 0.047 |
| **Агаарын чанарын стандарт MNS 4585:2016** | | | | **50** |

Шинжилгээ боловсруулсан: БОШЛабораторийн инженер /Т. Оюунгэрэл/

Хянасан: Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш. Мөнгөн /Ш. Мөнгөнцэцэг/

*Зураг 45. Агаарын чанарын шинжилгээний хариу*

# ГОВЬСҮМБЭР УЦУОШТ

## БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

### ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

2024 оны 10 сарын 04 өдөр          Дугаар 27          Чойр

| | |
|---|---|
| Дугаар, он /№ | : 09/18/2024 |
| Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас | : Жун- Юань ХХК |
| Дээжийг авсан хүний нэр, албан тушаал | : БОШЛ-ийн инженер /код-2/ |
| Дээжийн төрөл, тоо | : 1, Ус |
| Сорьц авсан огноо | : 2024.09.18 |
| Дээжийн хэмжээ | : 1 летр |
| Дээжийн тодорхойлолт | : Усны сорьц |
| Шинжилгээний аргын стандарт | : **MNS ISO 10523:2001, MNS ISO 8467:1999 : MNS ISO 7150-1:2006 MNS 4431:2005, :MNS ISO 6878:2001, MNS 6272:2011** |
| Шинжилсэн огноо | : 2024.09.18 – 2024.10.04 |
| Хуудасны тоо | : 1 |

| Сорьцын нэр | Ж/б | ПИЧ | $NH_4$ мг/л | $NO_2$ мг/л | $NO_3$ мг/л | $P_{эрд}$ мг/л | F мг/л |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Хэрэглээний ус** | 16.4 | 8.0 | 0.06 | 0.002 | 0.23 | 0.004 | 1.28 |

Шинжилгээ боловсруулсан: БОШЛабораторийн инженер /Г. Оюунгэрэл/

Хянасан: Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш. Мөнгөнцэцэг/

*Зураг 46. Усны шинжилгээний хариу*

# ГОВЬСҮМБЭР УЦУОШТ

## БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

### ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

2024 оны 10 сарын 04 өдөр    Дугаар 10

| | |
|---|---|
| Дугаар, он /№ | : 09/18/2024 |
| Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас | : Жун-Юань ХХК |
| Дээжийг авсан хүний нэр, албан тушаал | : БОШЛ-н инженер /код-2/ |
| Дээжийн төрөл, тоо | : 1, Ус |
| Сорьц авсан огноо | : 2024.09.18 |
| Дээжийн хэмжээ | : 1 литр |
| Дээжийн тодорхойлолт | : Усны сорьц |
| Шинжилгээний аргын стандарт | : **MNS ISO 10523:2001, MNS ISO 7888:1999 MNS 62715:2011 MNS 4424:2005** |
| Шинжилсэн огноо | : 2024.09.18 – 2024.10.04 |
| Хуудасны тоо | : 1 |

| Сорьцын нэр | PH | ES | $SO_4$ мг/л | Cl мг/л | Ca мг/л | Mg мг/л | Na+K мг/л | $HCO_3$ мг/л | Эрд мг/л | Хат мг/экв/л |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хэрэглээний ус | 8.00 | 858 | 209.5 | 75.2 | 1.09 | 46.0 | 112.8 | 177.0 | 642.3 | 4.87 |

Шинжилгээ боловсруулсан: БОШЛабораторийн инженер /Т. Оюунгэрэл/

Хянасан: Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш. Менгенцэцэг/

*Зураг 47. Усны шинжилгээний хариу*

# ГОВЬСҮМБЭР УЦУОШТ

## БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

### ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

2024 оны 10 сарын 04 өдөр Дугаар 26 [illegible]

Дугаар, он /№ : 09/18/2024
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : Жун-Юань ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : БОШЛ-ийн инженер /код-2/
Дээжийн төрөл, тоо : Хөрс агрохими
Сорьц авсан огноо : 2024.09.18
Дээжийн хэмжээ /гр/ : 200 гр
Дээжийн тодорхойлолт : Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум
Шинжилсэн огноо : 2024.09.18 – 2024.09.10.04
Хуудасны тоо : 2

| Д/д | Агрохимийн үзүүлэлтүүд | Нэгж | Цэг | Шинжилгээний дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Анхан шатны боловсруулалт | № | Кемп дотор | 10,7,5,3,2,1,0.5,0,25 мм-ийн хуурай шигшүүрийн арга |
| | | | Ачилт | |
| | | | Ялгалт | |
| | | | Хашааны гадна | |
| 2 | Сульфат /SO₄/ тодорхойлох | Мг/кг | Кемп дотор | 89.4 |
| | | | Ачилт | 164.3 |
| | | | Ялгалт | 217.2 |
| | | | Хашааны гадна | 20.7 |
| 3 | Фосфор /P₂ O₅/ тодорхойлох | Мг/кг | Кемп дотор | 4.15 |
| | | | Ачилт | 5.20 |
| | | | Ялгалт | 5.28 |
| | | | Хашааны гадна | 3.78 |
| 4 | Нитрат /NO₃/ тодорхойлох | Мг/кг | Кемп дотор | 4.59 |
| | | | Ачилт | 6.62 |
| | | | Ялгалт | 4.94 |
| | | | Хашааны гадна | 5.94 |
| 5 | Ялзмаг тодорхойлох | Мг/кг | Кемп дотор | 0.90 |
| | | | Ачилт | 0.91 |
| | | | Ялгалт | 0.96 |
| | | | Хашааны гадна | 0.91 |
| 6 | Аммони /NH₄/ | Огноо | Кемп дотор | 80.8 |

***Зураг 48. Хөрсний шинжилгээний хариу***



**Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information**

Журналын/Journal No: 000899847374

Системийн огноо/System Date:2024.10.16 14:15:52

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт/From | Дансны/Картын дугаар Account/Card number 5070361718 | Нэр/Name Н******О МӨНГӨНЧИМЭГТ | Дүн/Amount 180,000.00 MNT | Ханш/Rate 1.00 |
| / Нэг зуун наян мянган төгрөг/ | | | | |
| Кт/To | Банкны дугаар/Branch No 90<br>Дансны/Картын дугаар Account/Card number 100900013017 | Банкны нэр Bank Name Төрийн Сан<br>Нэр/Name БОХЗТ лаборатори | 180,000.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-2812231 Жун-Юань ГХОХХК хөрсний шинжилгээний төлбөр



**Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information**

Журналын/Journal No: 000901141703

Системийн огноо/System Date:2024.10.17 17:23:04

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт/From | Дансны/Картын дугаар Account/Card number 5070361718 | Нэр/Name Н******О МӨНГӨНЧИМЭГТ | Дүн/Amount 503,500.00 MNT | Ханш/Rate 1.00 |
| / Таван зуун гурван мянга таван зуун төгрөг/ | | | | |
| Кт/To | Банкны дугаар/Branch No 90<br>Дансны/Картын дугаар Account/Card number 100220013015 | Банкны нэр Bank Name Төрийн Сан<br>Нэр/Name Гс.УЦУОШТөв | 503,500.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-2812231 Жун-Юань ГХОХХК агаар, ус, хөрсний шинжилгээ

*Зураг 49. ОХШХ-ийн төлбөр төлсөн баримт*

# АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулан БОУАӨЯ-ны цахим системд илгээсэн болно.

# ДҮГНЭЛТ

Манай компани нь 2024 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Тоосжилт ихтэй үед зам усалгааг тогтмол хийж байсан.
- ✓ Уурхайн талбайд тэмдэг тэмдэглэгээг байршуулсан.
- ✓ Уурхайн гол тээврийн замыг шинээр тавьж, уулзвар, гарц бүрт тэмдэг тэмдэглэгээ шинээр байрлуулсан.
- ✓ Ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулж, ус ашигласны төлбөрийг төлсөн.
- ✓ Газар ашиглах гэрээг байгуулж, газрын төлбөрийг төлсөн.
- ✓ Нийгмийн хариуцлагын хүрээнд “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулж, эхний санхүүжилт болох 30.0 сая төгрөгийг төлсөн.
- ✓ Уурхайн замын далан шуудууг шинээр сэргээн засварласан.
- ✓ Тэсрэх материалын агуулах, болон шатахуун түгээгүүрийг шинэчлэн засварлаж, бүрэн камержуулсан.
- ✓ Уурхайн талбайд байрлах эвдэрсэн талбайг нөхөн дүүргэж, техникийн нөхөн сэргээлт хийсэн.
- ✓ Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Баянжаргалан сумын хогийн цэг болон сумын төвийн ойр орчны сэг зэмийг цэвэрлэхэд 2 өдрийн турш автомашин гарган ажилласан. Мөн сумын урд авто замын постны байшингийн сууринд 9 машин хайрга шороо асгаж, байшингийн суурийг бэлтгэсэн. Сумын хог хаягдлын цэгийг түрж бөөгнүүлэх, цэгцлэх ажлыг гүйцэтгэсэн.
- ✓ Хог хаягдлын гэрээ байгуулж, гэрээний дагуу тээвэрлүүлж байсан.
- ✓ Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан.
- ✓ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хөрс, ус, агаарын чанарын шинжилгээг Говьсүмбэр аймгийн УЦУОШТ-ийн байгаль орчны шинжилгээний лабораториор гүйцэтгүүлсэн.

2024 онд олборлолтын үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу явуулж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр хийгдэх ёстой ажлуудыг цаг тухайд нь хийж гүйцэтгэхийг хичээн ажилласан болно.